



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: *Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт*



Хуулийн талаар сурталчилгаа, мэдээллийг олон нийтэд түгээн, иргэдийн саналыг бүрэн тусгах шаардлагатай байна.

Ховд хот

2017 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Ховд аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар3 Ерөнхий зүйл4
Ховд аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Галбадрах Аудитын менежер А.Цэцэгсүрэн	Бүлэг 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх.....5 Дүгнэлт: <i>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим хөтөлбөрүүд хэрэгжих санхүүгийн эх үүсвэр тодорхой бус байна.</i> Бүлэг 2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх.....8
Аудитын баг: Аудитор Ц.Гантулга	Дүгнэлт: <i>Бодлогын баримт бичгийн тайлагнал хяналт-шинжилгээ , үнэлгээ хуулийн төвшинд хийгдэж байна.</i> Бүлэг 3. Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх.....11
2017 оны 12 дугаар сар <i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.</i> ХАЯГ: <i>Аймгийн ЗДТГазрын байр, 3 дугаар давхар 302, 309, 305 тоот өрөө</i>	Дүгнэлт: <i>Бодлогын баримт бичгийн мэдээлэл хангалтгүй байна.</i> Ерөнхий дүгнэлт: <i>Хуулийн хэрэгжилтийн талаархи сурталчилгаа хангалтгүй, зарим хөтөлбөрүүд хэрэгжих санхүүгийн эх үүсвэр тодорхой бус байна</i> 12 Зөвлөмж: Холбогдох байгууллагын санал..... Хавсралтууд:.....

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХБББ	Хөгжлийн бодлогын баримт бичиг
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХШҮДАХ	Хяналт- шалгалт үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХЭЗХ	Хууль эрх зүйн хэлтэс
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлогын төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрхи зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх.

Хамрах хүрээ: Энэхүү аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөгдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймгийн ИТХ, Засаг дарга, түүний харъяа агентлаг, байгууллага, сумдын засаг даргын тамгын газрууд зэрэг төрийн байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын журмыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашигласаны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа: Аудитыг аймгийн Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн хянан, аудитор Ц.Гантулга 2017 оны 10 дугаар сарын 20-ноос 12 дугаар сарын 01-нийг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Тус аудит нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичигдлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн хөгжлийн бодлогын бичиг баримт нь Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулинд нийцсэн байх шаардлагатай.

Энэхүү хуульд “Хөгжлийн бодлогын баримт бичиг”-ийг “үндэсний салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан баримт бичиг” гэж тодорхойлсон.

Аудитын төлөвлөлтийн шатанд аймгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн судалгаагаар нийгэм эдийн засгийн стратеги төлөвлөгөө 15, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 18, эдийн засаг ниймийг хөгжүүлэх үндсэн чиглэл 18 бүгд 51 хөгжлийн бодлогын баримт бичиг хэрэгжиж байна гэсэн мэдээлэл ирүүлсэн байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахад Засгийн газрын 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг баримталж бодлогын баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус мөрдөж байна.

БҮЛЭГ 1: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны зарим хөтөлбөрүүд хэрэгжих санхүүгийн эх үүсвэр тодорхой бус байна.

Ховд аймагт Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулинд зааснаар урт хугацааны бодлогын баримт бичиг -3, богино хугацааны -3, дунд хугацааны – 138, бүгд 144 бодлогын баримт бичиг, хөтөлбөр хэрэгжиж байна.

1.1 Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030, Төрөөс баримтлах бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого, Ховд аймгийг хөгжүүлэх стратеги /2015-2025 он/, Сумдыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Аймаг сумдын эдийн засаг ниймийг хөгжүүлэх чиглэл, Ховд ногоон хөгжил болон бусад хөтөлбөр, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, аймаг, сумдын Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс хариуцан төлөвлөн боловсруулж хэрэгжилт, үр дүнг нь тооцон ажиллаж байна.

Хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүд:

Хугацаа	Бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн төрөл, нэр	Хэрэгжиж байсан эсэх	Батлагдсан он, сар, өдөр	тоо
Урт хугацааны	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	тийм	2016.02.05	1
	Төрөөс баримтлах бодлого	тийм	2016	1
	Бүсчилсэн хөгжлийн бодлого	тийм	2016	1
Дүн				3
Дунд хугацааны	УИХ, МУ-ын Засгийн газрын үндэсний хөтөлбөр	шинээр-63 үргэлжлүүлэн хэрэгжүүлэх-14	2013-2025 /харилцан адилгүй хугацаатай/	77
	Ховд аймгийг хөгжүүлэх стратеги / 2015-2025 он/	тийм	2014.10.21	1
	Сумдыг хөгжүүлэх стратеги /мастер/ төлөвлөгөө /2010-2023 он/	тийм	2010, 2012, 2013,2014	17
	Ховд ногоон хөгжлийн хөтөлбөр /2016-2026 он/	үгүй	2016.10.24	1
	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2016-2020 он/	тийм	2016.12.02	1
	Сумдын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	тийм	2016	17
	“Чадварлаг Ховдчууд” хөтөлбөр	тийм	2017.05.10	1
	“Эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах” хөтөлбөр	тийм	2017.02.08	1
	“Эх хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ” хөтөлбөр	үгүй	2017.02.08	1
	“Жендерийн тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр	үгүй	2017.11.03	1
	“Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих” хөтөлбөр	тийм	2017.05.10	1
	“Спортын аварга” хөтөлбөр	тийм	2017.02.08	1
	“Ахмадаа ачилъя” дэд хөтөлбөр	тийм	2017.05.10	1
	“Олон нийтийн оролцоот Сургууль хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөр	үгүй	2017.11.03	1
	“Олон үндэстэн ястны өв соёл” хөтөлбөр	тийм	2017.05.10	1
	“Үйлчилгээний ээлтэй орчин” хөтөлбөр	тийм	2017.02.08	1
	“Оюун түлхүүр” дэд хөтөлбөр	үгүй	2017.11.25	1
	“Цахим номын сан” дэд хөтөлбөр	үгүй	2017.11.25	1
	“Залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр	үгүй	2017.11.25	1
	“Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах” дэд хөтөлбөр	үгүй	2017.11.25	1
	“Өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөр	тийм	2016	1
	“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах “ дэд хөтөлбөр	тийм	2016	1
	“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр	үгүй	батлагдах шатандаа	1

	Нягтлан бодох бүртгэлийн “Тунгалаг бүртгэл” хөтөлбөр	үгүй	2017.05.10	1
	“Шилмэл мал” дэд хөтөлбөр	үгүй	2017.08.09	1
	“Залуу малчин” хөтөлбөр	үгүй	2017.11.03	1
	“Эко хүнс” хөтөлбөр	үгүй	батлагдах шатандаа	1
	“Тайван-Амгалан-Ховдчууд” хөтөлбөр	тийм	2017.05.10	1
	“Гурван цэнхэр од төвтэй аялал жуулчлал” хөтөлбөр	үгүй	батлагдах шатандаа	1
	Төрөөс эрүүл мэндийн талаар баритлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр	үгүй	2017.08.09	1
	Дүн			138
Богино хугацааны	Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	тийм	2016	1
	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	тийм	2016	1
	Сумдын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	тийм	2016	1
Дүн				3
Нийт дүн				144

Дээрхи бодлогын бичиг баримтуудаас Монгол улсын УИХ, ЗГ-аас хэрэгжүүлэх 77 үндэсний хөтөлбөрөөс 2016-2020 оны засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсанаар шинээр боловсруулан хэрэгжүүлэх 63, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 14 хөтөлбөр байгаагаас 2016 онд 19, 2017 онд УИХ-ын тогтоолоор 7, Засгийн газрын тогтоолоор 32 бүгд 58 үндэсний хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна.

1.2 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймгийн хэмжээнд нийт 65, үүнийг хэрэгжүүлэх 108 арга хэмжээ байгаагаас сумдад 47 зорилт, 74 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгажээ.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны 4 бүлэг, 22 дэд бүлэг, 98 зорилт бүхий үйл ажиллагааны хөтөлбөрийг ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 2/03 тоот тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.

Мөн “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төрөөс баримтлах бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого, МУ-ын Их хурал, Засгийн газрын үндэсний хөтөлбөр, “Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” “Ховд аймгийг 2015-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-нд тулгуурлан аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан орон нутгийн хөгжлийн болон бусад сангийн эх үүсвэрээр хэрэгжих 13 хөтөлбөр, 12 дэд хөтөлбөр бүгд 25 хөтөлбөр хэрэгжихээс шинээр хэрэгжүүлэх 23, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр байгаагаас аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор 18 хөтөлбөр батлагдаж 7 хөтөлбөр батлагдах шатандаа байна.

Хэрэгжиж буй урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдэд үйл ажиллагаа, утга агуулга, чиглэл зорилтын тухайд давхцал байхгүй, хэрэгжих цаг хугацааны хувьд харилцан адилгүй байна.

1.3 Зарим хөтөлбөрүүдийн санхүүжилтийн хэсгийг бусад эх үүсвэрээс бүрдүүлэн хэрэгжүүлнэ гэж төлөвлөжээ. Тухайлбал: “Эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах” хөтөлбөр 38,7 сая, “Эх хүүхдийн ээлтэй тусламж, үйлчилгээ” хөтөлбөр 32,0 сая, “Олон нийтийн оролцоот сургууль-Хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөр 27,0 сая, “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр 100,0 “Залуу малчин” хөтөлбөр 150,0 “Шилмэл малчин” 15,0 сая гэх мэт.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журмын дагуу хэрэгжүүлэхгүй, тухайн ажил хариуцсан мэргэжилтний түвшинд хийгдсэн байна.

1.4 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг 2016 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/460 дугаар захирамжаар баталж эдийн засгийн хөгжлийн бодлого, нийгмийн бодлого, байгаль орчин ногоон хөгжлийн бодлого, засаглалын бодлого гэсэн чиглэлүүдээр хэрэгжилтийг хангуулж ажиллахаар байгуулагджээ.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг төлөвлөж, боловсруулахдаа МУ-ын ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолын дагуу “Гурван цэнхэр төвтэй таван од аялал жуулчлал”, “Ногоон хөгжил”, “Залуу малчин” хөтөлбөр боловсруулагдсан байхад бусад хөтөлбөрүүд дээрхи тогтоолыг төгс баримтлаагүй тухайн ажил хариуцсан мэргэжилтний түвшинд хийгдсэн гэж үзэхээр байна. Тухайлбал:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн талаархи аймгийн Засаг даргын албан бичгийг сум, харьяа байгууллагуудад хүргүүлэн саналыг авч нэгтгэн ажлын төлөвлөгөө боловсруулсан албан ёсны нотлох баримт материал байхгүй,
- ХБББ-ийг боловсруулахдаа бодлогын баримт бичгийн хувилбаруудад урьдчилсан үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийгээгүй, зөвхөн Жаргалант сумын 12 баг, зарим байгууллагуудад албан тоот хүргүүлсэнээс өөр эрдэмтэн судлаачид, өргөн олныг хамруулан зохион байгуулсан ажил хийгдээгүй,
- Хөгжлийн бодлогын баримт бичигт хүрэх үр дүнг тодорхойлсон боловч түүний санхүүгийн эх үүсвэрийг бодитой судалгаанд тулгуурлан хийсэн тооцоолол үгүй байна.

**БҮЛЭГ 2: Бодлогын баримт бичгийн тайлагнал, хяналт шинжилгээ
үнэлгээ хуулийн түвшинд хийгдэж байна.**

2.1 Ховд аймаг бодлогын бичиг баримтаа аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/347 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны болон төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг үндэс болгон захирамжинд заасан аргачлалын дагуу сум байгууллагуудаас бодлогын баримт бичгийн тайлагналыг авч байна.

Хүснэгтээр харуулбал:

д/д	Баримт бичгийн төрөл	Хүлээн авах байгууллага	Тайлан ирүүлэх болон хүргүүлэх хугацаа		
			Хэлтэс, сум, байгууллага	ЗДЗ-ийн хуралд оруулах	ЗГХЭГ-т хүргүүлэх
1	Төрөөс баримтлах бодлого	ТЗУХ, ХЭЗХ, ХОХБТХ, НБХ	12.25	01.15	02.01
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	ТЗУХ	06.10 12.25	01.15 06.25	02.10 07.10
3.	Үндэсний хөтөлбөр	ТЗУХ	12.25	02.01	02.10
4.	Ховд аймгийн хөгжлийн стратеги /2015-2025/	ХОХБТХ	01.10	02.10	02.20
5.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр	ТЗУХ	11.15 05.15	11.25 05.25	02.20
6.	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	ХОХБТХ	11.15 05.15	11.25 05.25	02.20
7.	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр	ТЗУХ ХОХБТХ	12.25	01.20	02.01
8.	Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	ТЗУХ ХОХБТХ	12.25	01.20	02.01

Бодлогын баримт бичгүүдийн тайлан хүлээн авах байгууллага, ирүүлэх болон хүргүүлэх хугацаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн холбогдох заалт, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт, бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцсэн байна гэж үзлээ.


Бодлогын баримт, бичгийн хяналт- шинжилгээ, үнэлгээг ХШҮДАХ-аас хэрэгжүүлэн ажилласан байна.


2.2 Засаг дарга А/347 тоот захирамжаараа аймгийн хэмжээнд бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх асуудлыг Засаг даргын тамгын газрын ХШҮДАХ /Хяналт шалгалт үнэлгээний дотоод аудитын хэлтэс/-т хариуцуулжээ.

ХШҮДАХ нь нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, аймаг хөгжүүлэх хэтийн зорилт зэрэг баримт бичгүүдийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ИТХ-д танилцуулан тухайн оны 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх хуулийн заалтын дагуу 2018 онд үнэлгээ хийж хүргүүлэхээр ажиллаж байна.

Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Хөгжимт драмын театрын үйл ажиллагаа , бодлогын бичиг баримтын хэрэгжилтэнд, сум, байгууллагуудын үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах ажил жил бүрийн хагас, бүтэн жилээр хийжээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн дагуу Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд 2016 оны эцсийн байдлаар хяналт- шинжилгээ үнэлгээ хийсэн байдлыг графикаар харуулав.





Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байдлаас үзэхэд тухайн онд нийт 69 хөтөлбөрийн 291 зорилт хэрэгжсэнээс салбараар нь авч үзвэл Байгаль орчин аялал жуулчлал, Дэд бүтэц үйлдвэрлэл, Эрүүл мэнд, Хүнс хөдөө аж ахуйн салбарт зонхилох хэсэг нь хэрэгжиж хэрэгжсэн нийт хөтөлбөр дунджаар 74,2 хувийн биелэлттэй хэрэгжсэн үнэлгээний дүнтэй байна.

БҮЛЭГ 3: Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Бодлогын баримт бичгийн мэдээлэл хангалтгүй байна.

3.1 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймгийн удирдах зөвлөлгөөнд оролцсон сум, байгууллагын удирдлагууд болон нийт 220 гаруй албан хаагчдад журмын талаар танилцуулга хийж хэлтэс, сум, байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээ, бодлогын баримт бичиг эрх зүйн актуудын биелэлт хариуцсан 60 гаруй мэргэжилтэнд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулжээ.

3.2 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.1. дахь заалтын дагуу олон нийтэд ил тод мэдээллийг аймгийн Телевиз, Фэйсбүүк хуудас, мэдээллийн самбар, хэвлэл мэдээллээр улирал бүрээр нийтэлж байгаа хэдий ч хөтөлбөр хариуцсан салбаруудын мэдлэг, мэдээлэл дутмаг байна.

3.3 Аймгийн нэгдсэн сайт дээр хөгжлийн бодлогын талаар цэс байхгүй энэ талаархи мэдээллээ байршуулж сурталчилж байгаа сум, салбар байгууллага

байхгүй байна.

Ерөнхий дүгнэлт: Хуулийн хэрэгжилтийн талаархи сурталчилгаа хангалтгүй, зарим хөтөлбөрүүд хэрэгжих санхүүгийн эх үүсвэр тодорхой бус байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Б.Ганболд нарт

- Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг салбар хариуцсан мэргэжилтэн бүрт тэгш хувиарилан хариуцуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах
- Хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдийн талаар төсөвт байгууллагууд, сумдын Засаг даргын холбогдох мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах
- Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бусад эх үүсвэрээр хэрэгжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийг тодорхой болгох
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд ил тод мэдээллэх цахим хуудсыг 2018 онд нээж иргэдийн саналыг тусган ажиллах

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.ГАНТУЛГА

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 44

Ховд

Аудитын тайлан, зөвлөмж,
батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан "акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1, 4.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын дэргэдэх зөвлөлийн 2017 оны 12 сарын 19-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын тайлан, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Нийцлийн аудитын дүгнэлтэнд үндэслэн аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх, Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Б.Ганболд нарт ДААЛГАХ нь:

2.1 Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг салбар хариуцсан мэргэжилтэн бүрт тэгш хувиарилан хариуцуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах.

2.2 Хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдийн талаар төсөвт байгууллагууд, сумдын Засаг даргын холбогдох мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах.

2.3 Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бусад эх үүсвэрээр хэрэгжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийг тодорхой болгох.

2.4 Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд ил тод мэдээлэх цахим хуудсыг 2018 онд нээж иргэдийн саналыг тусган ажиллах.

3. Нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын нийцлийн аудитын газарт хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Ц.Гантулгад даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ГАЛБАДРАХ

0800042

0700012

Холбогдох байгууллагын санал

Байгууллагаас ирүүлсэн тайлбар:

Аймгийн Засаг даргын тамгын газрын ХБТХ, ТЗУХ-ын дарга, мэргэжилтэнүүдэд танилцуулан холбогдох саналыг хүлээн авч аудитын тайланд туслав.



МОНГОЛ АМААГ ДАХЬ ТӨМӨРИН АУДИТЫН ГАЗАР

Төний газраас: Хөгжлийн бодлого төлөвлөлтэд түүн хүрнээ хэрэгжлэгдээд байсан мөрийн үзүүлэлт дүнгийн танилцуулга

Аудитын өргөдөл мөрийн бодлого төлөвлөлтөд түүн хүрнээ хэрэгжлэгдээд байсан мөрийн үзүүлэлт дүнгийн танилцуулга



Хөгжлийн бодлого төлөвлөлтөд түүн хүрнээ хэрэгжлэгдээд байсан мөрийн үзүүлэлт дүнгийн танилцуулга



МОНГОЛ АМААГ ДАХЬ ТӨМӨРИН АУДИТЫН ГАЗАР

Төний газраас: Хөгжлийн бодлого төлөвлөлтөд түүн хүрнээ хэрэгжлэгдээд байсан мөрийн үзүүлэлт дүнгийн танилцуулга

Аудитын өргөдөл мөрийн бодлого төлөвлөлтөд түүн хүрнээ хэрэгжлэгдээд байсан мөрийн үзүүлэлт дүнгийн танилцуулга



Хөгжлийн бодлого төлөвлөлтөд түүн хүрнээ хэрэгжлэгдээд байсан мөрийн үзүүлэлт дүнгийн танилцуулга

УАС-ХОА-2017/07-НА